*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ТЭТГЭВРИЙН ТОГТООЛТ, ОЛГОЛТЫН БАЙЦААГЧ
БЯМБААГИЙН ЦЭЦЭГДЭЛГЭРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1.1 | Сар бүрийн тэтгэврийг олгох, олголтонд хяналт тавьж, үүссэн зөрчлийг тухай бүр зассаж залруулах | Тэтгэврийг хуулийн дагуу олгосон байна. | 14278 | 15136 | Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт-**15136** тэтгэвэр авагчдад **123,4** тэрбум төгрөгийн тэтгэврийг 5 банкаар дамжуулан олгож байна.<br>• Өндөр нас - 11302<br>• Тахир дутуу - 2408<br>• Тэжээгчээ алдсаны- 559<br>Цэргийн тэтгэвэр авагч - **729**<br>ҮОМШӨ-ний тэтгэвэр авагч - **53**<br>• Тахир дутуу - 41<br>• Тэжээгчээ алдсаны- 12<br>Тусгай зохицуулатын тэтгэвэр авагч- **85** иргэн байна.<br>Мөн тэжээгчээ алсаны тэтгэвэр хуваан авдаг **11** тэтгэвэр авагчийн тэтгэврийг сар болгон гараар жагсаалт үйлдэж банканд хүргүүлэн ажиллаж байна. Энэ нь программд мэдээлэл орсон боловч хуваах мөнгөн дүн зөрүүтэй татагдаад байна.<br>Тэтгэвэр олголтын файлыг сар бүрийн 30-ний өдөр харилцагч банк тус бүрээр бэлтгэн, тэтгэврийг төрөл тус бүрээр программийн мэдээлэлд тулгуурлан бэлдэж, тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, газрын | 2024-01-01<br>2024-12-31 | 106,0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даргаар баталгаажуулсны дараа сүлжээний зохицуулагчийн хамт банкинд хүргүүлэн сар бүрийн 01-ний дотор хуулийн хугацаанд бүрэн олгон ажиллаж байна.<br>-Өмнөх онд нийт тэтгэвэр авагч 14278 байсан бол энэ онд 15136 тэтгэвэр авч болж 858 тэтгэвэр авагчаар өссөн байна. Энэ нь тусгай зохицуулаттын тэтгэвэр буюу нас барсан тэтгэвэр авагчийн 20 хувийн тогтоож олгосонтой холбоотойгоор нийт тэтгэвэр авагчийн тоо өссөн үзүүлэлт ажиглагдаж байна. Шинэ систем SICOS программ нэвтэрсэнтэй холбоотойгоор иргэдийн тэтгэвэр орохгүй үлдэх бухимдал үүссэн асуудал их гарсан, асуудлыг жирагаар явуулж, зүгээр авч байсан тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэлт олголтоор олгох холбогдох арга хэмжээг тухай бүр авч асуудлыг түргэн шуурхай шийдэж ажиллаж байна.<br>Засгийн газрын 2024 оны 03дугаар сарын 20-ний өдрийн хуралдаанаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100000 нэмэгдүүлэн шийдвэрийн дагуу бүрэн тэтгэврийн хэмжээ 650000 төгрөг, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээ 540000 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоож, аймгийн нийт 14675 тэтгэвэр авагчдын тэтгэврийг өмнөх сарынхаас 1 тэрбум 68 сая 773 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд тэтгэвэр авагдын дундаж 761773 болж, тэтгэвэр авагчдын дундаж тэтгэвэр **15,1** хувиар өссөн байна.<br>-Банк сольсон нийт **825** тэтгэвэр авагчдад үйлчилгээ үзүүлсэн энэ нь ажлын ачааллыг маш ихээр нэмэгдүүлсэн.<br><br>SICOS программ мэдээллийг оруулж өөрчлөгдөөгүй иргэд гомдол гаргасан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | асуудлыг тухай бүр шийдэж ажилласан. Шалтгаан нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын нас барагч иргэний регистрээр хийж банк сольдог учраас уг үйлдэл нь шинэ системд мэдээллийг 9 сараас татаж эхэлж одоогоор гомдолгүй ажиллаж байна. | | |
| 1.2 | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын дагуу өөрчлөлтийн мэдээллийг мэдээллийн санд оруулж, тэтгэвэр олголтын бэлтгэж хянуулах | Тогтоосон хугацаанд тэтгэврийг олгосон байна. | 2738 | 2754 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар орсон 2665 тэтгэвэр авагчийн группын сунгалтын хугацааг программд оруулж, 7 хоног бүрийн 2 дахь өдөр нэмэлт тэтгэвэр өгч, ХЧА хувь, хугацаа, тогтоосон актыг хувийн хэрэгт тогтмол хийн ажиллаж байна. SICOS программд сунгалтын хугацаа оруулан хөдөлгөөнийг хийж долоо хоног бүрийн мягмар гаригт файлыг тогтоосон хуваарийн дагуу жагсаалт үйлдэн тухайн иргэний банкны дансыг утасдаж авч, гар жагсаалтанд бичиж, гүйлгээ хийж банканд өгч ажиллалаа. | 2024-01-01<br>2024-12-31 | 100,1% |
| 1.3 | Ажилласан жилийн нэмэгдлийг тооцох, тэтгэвэр тогтоолтын хуудсыг хэвлэж, хувийн хэрэгт хавсаргах хянуулах | Тогтоосон хугацаанд нэмэгдлийг олгосон байна. | 134 | 326 | Тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд:<br>• Ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан өндөр нас -287<br>• Цэргийн тэтгэвэр авагч болон өндөр настны -41<br>нийт 326 тэтгэвэр авагчдад 4768676 мянган төгрөгөөр өөрчлөн тогтоож олгоод байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 123,8% |
| 1.4 | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулах,мэдээллийн сангийн бүрдэлт,баяжилтанд хяналт тавих | Тэтгэврийн шилжилт хөдөлгөөн хийж, мэдээллийн санд орсон байна | Жилийн турш | Жилийн турш | Тэтгэврийн шилжиж ирсэн, шилжиж явсан, нийт 153 тэтгэвэр авагчийн хөдөлгөөний тухай бүрт мэдээлэлийг SICOS программд оруулан хөдөлгөөнийг хийж бүртгэл хөтлөн ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Өмнөх онд 414 иргэн хамрагдсан, буурсан үзүүлэлтийн гол шалгаан нь тэтгэвэр авагч иргэний харъяалал заавал аймгийн төвийн харъяалалтай байх шаардлага тавьсан байсан бөгөөд сумын тэтгэвэр авагчдад Хаан, Төрийн банк гэсэн 2 сонголттой байсан нь аймагруу шилжиж ирэх гол шалтгаан болсон, энэ онд Худалдаа хөгжил, Голомт банкууд зээлийг аймаг сум харгалзахгүй олгож байгаатай холбоотой. | | |
| 1.5 | Нас барсан тэтгэвэр авагчдын хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулах, мэдээллийн сангийн бүрдэлт, баяжилтанд хяналт тавих | Мэдээллийн санд бүртгэл хийгдсэн байна. | 369 | 380 | НДЕГ-ын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/2271 дүгээр албан бичгийг баримтлан нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 380 материалыг шалган хүлээн авч жагсаалт үйлдэж, тэтгэмжийн байцаагчид хуулийн хунацаанд нь өгч ажилласан. | 2024-01-01<br>2024-12-31 | 102,9% |
| 1.6 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн тогтоолын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврээс суутгал хийх болон суутгал зогсоох тухай мэдэгдлийг мэдээллийн санд оруулж бүртгэх, холбогдох суутгалыг хийж, бүртгэл үйлдэн сангийн нягтлан бодогчид хүргүүлэх | Тэтгэврийг хуулийн дагуу олгосон байна. | 3 | 5 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасны дагуу суутгал хийлгүүлэх тэтгэвэр авагчдыг үндсэн файлаас хассан, тэтгэвэр авагч банкруу нь гар жагсаалтаар олгож, шүүхээр авах суутгалыг Санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогчид сар бүрийн 01-нд жагсаалт өгч хяналт шалгалтын байцаагчаар хянуулан ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 101,0% |
| 1.7 | Улсын байцаагчийн актаар тавигдсан зөрчлийг тухай бүр арилгах, сар бүрийн тэтгэврээс суутгаж, тооцоог гарган тайлагнах | Зөрчлийг арилгуулсан байна. | Жилийн турш | Жилийн турш | Тус газрын 2023 оны тэтгэврийн тогтоол олголтыг Захиргаа, хяналтын хэлтсийн даргын удирдамжийн дагуу, хяналт шалгалтын байцаагчийн актаар гарсан дутуу олгосон 758351 төгрөг, илүү 3233203 олгосон төгрөгийг 2 улиралд бүрэн барагдуулсан бөгөөд 1 иргэний жилийг дутуу тооцож олгосон 4642590 төгрөгийн зөрүүг нөхөж олгосон. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 06 тоот улсын байцаагчийн актаар 14 иргэний 5187180 төгрөгийн илүү олголтыг, 18 иргэний дутуу олгосон 3235628 төгрөг, 12сарын 02 өдрийн 32 иргэний 13,748,249 төгрөгийн илүү олгосон мөнгийг буцаан төлүүлж барагдуулаж ажиллаж байна.<br>НДЕГ-ын даргын 2024 оны 11 сарын 06 өдрийн баталсан удирдамжийн дагуу 5 жилийн 2019-2023 онд тогтоогдсон шинэ тэтгэвэрт хийсэн хяналт шалгалтаар илэрсэн илүү олгосон, зогсоох тэтгэвэр авагчдын хөдөлгөөнийг хийж, дутуу олгох 1530805 төгрөгийн тэтгэврийг нөхөн олгоод байна. Тэтгэврийн сангаас илүү олгосон тэтгэврийг тухай бүрт нь буцаан төлүүлэх ажлыг тогтомол хийж гүйцэтгэж ажиллалаа. | |
| 1.8 | Тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсэн болон дундаж цалин оруулах хүсэлт өгсөн тэтгэвэр авагч иргэдийн тушаал, цалингийн тодорхойлолтын үндэслэлийг аж ахуйн нэгж, байгууллага дээр очиж шалгах баталгаажуулах. | Тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Жилийн турш | Жилийн турш | Тэтгэвэр дундаж цалин хөлсгүйгээр тогтоолгосон тэтгэвэр авагч 5 жилийн цалин хөлсөөр, эсхүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай” А/136 дугаар тушаалаар баталсан жишиг цалингаар тэтгэврээ өөрчлөх тогтоолгох хүсэлт гаргасан 3 тэтгэвэр авагчаас 1 иргэний цалин үндэслэлгүй учир нэмэгдэл хийгдээгүй, тус тэтгэвэр авагчдад утсаар мэдэгдэж материалыг өгч, 2 тэтгэвэр авагчийг цалинтай болгон өөрчлөн 198,5 мянган төгрөг тооцож тэтгэврийн нэмэгдлийг хийж олгоод байна. Иргэдийн авчирсан цалингийн тодорхойлолтыг хяналт шалгалтын байцаагчид өгч цалингийн үндэслэлийг тулган шалгуулж баталгаажуулан авч өөрчлөлтийг хийж ажиллаж байна. | 2024-01<br>2024-12 |
| **Зорилт 2. “ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх ” зорилтын хүрээнд** | | | | | | |
| 2.1 | Нэгжийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн өөрийн ажлын | Холбогдох хууль тогтоомжийн | 2 | 2 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаандаа батлуулж биелэлтийг 2 удаа | 2024-0<br>2024-1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах | дагуу хийсэн байна. | | | бичиж, тушаал шийдвэрийг, шаардлагатай тоо баримт мэдээллийг хугацаанд нь гаргаж ажиллаж байна. | | |
| 2.2 | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах | Мэдэгдлийн тухай бүр гаргаж тайлагнасан байна. | Жилийн турш | Жилийн турш | Төрийн албаны стандарт, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд мэдүүлэн, ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |
| 2.3 | Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээ,тайлан, судалгаа гаргах, танилцуулах | Мэдээ тайлан, судалгааг үнэн зөв, хугацаандаа гаргасан байна. | Тухай бүр | Тухай бүр | Төсвийн тухай хуулийн дагуу тайлан мэдээг заасан хугацаанд гаргаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2 удаа гаргаж, тэтгэврийн холбогдох судалгаа, мэдээ тайланг тухай бүрт гаргаж удирдлагад ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |
| 2.4 | Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлэх ажиллах, бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хувийн хэргийг нэрсийн жагсаалтын дагуу жилийн эцэст архивд хүлээлгэн өгөх | Мэдэгдлийн тухай бүр гаргаж тайлагнасан байна. | 8177 | 8622 | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг хяналт шалгалтын тасаг, тэтгэврийн 2 байцаагчтай хамтран, 2024 оны 4 дугаар сарын 20-25-ны хооронд, Хэрлэн сумын 8622 тэтгэвэр авагчдын хувийн хэрэгт тооллого явууллаа.<br><br>Өндөр насны тэтгэвэр- 6521<br>Тахир дутуугийн тэтгэвэр- 1673<br>Тэжээгчээ алдсны тэтгэвэр- 428<br>НДЕГ-ын даргын 2024оны 11 сарын 06 өдрийн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын багийнхантай хамтран хувийн хэрэгт тооллого хийхэд дутсан болон үрэгдүүлсэн хувийн хэрэг байхгүй.<br><br>Нийт зогсоогдсон: **509**<br><br>• Өндөр настан - 222<br>• Тахир дутуу - 264<br>• Тэжээгчээ алдсан -22<br>Тэтгэвэр авч байгаад нас барсан, зогссон хувийн хэргийг архивын ажилтанд | 2024-01-01<br>2024-12-31 | 105,4% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | массивын дараалал тус бүрээр нь ангилан ялгаж архивт хүлээлгэн өгсөн. НДЕГ-ын даргын 2024 оны 11 сарын 06 өдрийн баталсан удирдамжийн дагуу 5 жилийн 2019-2023 онд тогтоогдсон шинэ тэтгэвэрт хийсэн хяналт шалгалтаар тэтгэврийг хувийн хэргийг гаргаж хүлээлгэн өгч, хүлээн авчсан, дутсан хувийн хэрэг гараагүй болно. | | |
| 2.5 | Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн санал гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор | Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор | Засгийн газрын 11-11 төвд 2 иргэний гомдол ирснийг тухай бүрд нь шуурхай шийдвэрлэж гомдол гаргасан иргэнтэй холбогдож хариуг мэдэгдэн ажиллалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэд даатгуулагчидтай харилцах нээлттэй утас 70585955 утсыг "Call pro" үйлчилгээнд холбосонтой холбоотой тэтгэврийн талаар мэдээлэл авахаар тус утсанд холбогдсон иргэд даатгуулагчдын дуудлага бүрийг хариуцлагатай авч хүссэн мэдээллийг өгч ажилласан ба алдсан дуудлагыг эргэн холбогдож тэтгэвэр авагчдад биеэр болон утсаар, ирүүлсэн хүсэлтүүдийг тухай бүрд нь түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |
| 2.6 | Хөдөлмөрийн дотоод журам,үйл ажиллагааны хүрээнд гарсан бусад дүрэм журам,зааврыг мөрдөж ажиллах | Дүрэм, журам, зааврыг мөрдөж ажилласан байна. | Тухай бүр | Тухай бүр | Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох журам зааврийн дагуу ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр нь биелүүлэн ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |
| 2.7 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавраар ажил гүйцэтгэх, танилцуулах, шаардлагатай тохиолдол ажил орлон гүйцэтгэх | Тухай бүр гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэсэн байна. | Тухай бүр | Тухай бүр | Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг цаг хугацаанд нь чанартай үнэн зөв гаргаж, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн №450 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгуулагч тэтгэвэр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгох журамын дагуу, тэтгэврийн тогтоолтын байцаагчийг байхгүй үед ажлын түр орлон нийт 42 иргэний | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэтгэврийг шинээр тогтоож, 8 хүний 20 хувийн нэмэгдэл, тэтгэвэрт гараад ажиллаж байгаа 6 иргэний 1,5 хувийн нэмэгдлийг, нас барсан тэтгэвэр авагч 29 иргэн, банк солих 51 иргэн, ЭХМК-ийн 23 иргэний сунгалт хийж нийт **159** холбогдох баримт материалыг хяналтын байцаагчид өгч шийдвэрлүүлэн баталгаажуулж ажилласан. | | |
| 2.8 | Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах. | Зохион байгуулагдсан ажилд идэвхитэй оролцсон байна. | Тухай бүр | Тухай бүр | "Илүүдэл жингүй, төрийн албан хаагч аяны хүрээнд өглөө 8 цагт биеийн тамир спортын ордонд хамт олноороо оролцож байна.<br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Бүх нийтээр мод тархи үндэсний өдөр"-ийн хүрээнд тус хэлтсийн нийт албан хаагчид 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Чойбалсан олон улсын нисэх буудлын зам дагуух талбайд мод тарьсан. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил | Зохион байгуулсан сургалт сурталчилгааны тоогоор | Тоогоор | Тоогоор | 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж авлага барагдуулах аян"-ы А/79 тоот удирдамжийн дагуу 3-р багт хуваарилагдан тэтгэврийн хяналтын байцаагч Т.Ариунаа, сангийн нягтлан бодогч Б.Бямбаа, нартай хамтран нийт 66 байгууллагын 399,385,531 сая төгрөгийн өртэй байгуулагад албан шаардлага өгч, урьдчилан утсаар холбогдож, данс хаах зэрэг ажлыг хамтран зохион байгуулж, бүх байгууллагад хүрч ажиллан 92,4 хувьтай авлага барагдуулсан. | 2024-01-01<br>2024-12-31 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Нийгмийн даатгалд даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх | Сайн дурын даатгалд 10 шинэ даатгуулагч хамруулсан байх | 10 | 16 | Тус аяны хүрээнд 10 баг, 3 багийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сууртчилан танилцуулж сайн дурын даатгалд 1, малчин 2, эх 1 нийт 4 иргэнийг шинээр хамруулж, 2, 3 багт ажиллахдаа тэтгэвэрт гарахад жилээ тооцуулж бодуулахад жил тутсан 2 иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сдд хамруулж, 1 иргэнийг энгийнээр, 1 иргэнийг 900000 мянган төгрөгөөр сдд хамруулж, шилжиж ирсэн 1 иргэнийг 89100 төгрөгөөр тус тус хамруулсан ба, нээлттэй хаалганы өдөрлөгийн газрын хамт олноороо зохион байгуулж, 2 иргэнийг 89100, 1 иргэн хөгжлийн бэрхшээлттэй хүүхдээ хардаг 13200 шинээр даатгуулан сдд байцаагчид материалыг нь өгч гэрээ байгуулан ажилласан.<br>Иргэд даатгуулагчдыг та нийгмийн даатгалд хамрагдсан уу, мэссэжийг гар утасруу явуулж багаараа шинэ үйлчилгээ нэвтрүүлж,нийт 9 иргэнийг шинээр хамруулж ажилласан. **/Нийт 16 иргэнийг хамруулан ажиллаж холбогдох,гэрээ,шимтгэл төлсөн лавлагааг хүн тус бүрээр хавсаргав/.** | 2024-01-01<br>2024-12-31 | 114% |
| 3. | Нийгмийн даатгалын сангийн 2025-2027 оны төсвийн төсөөлөл боловсруулах ажилд оролцох | Судалгаа мэдээллийг гаргах өгсөн байх | Тоогоор | Тоогоор | Нийгмийн даатгалын газраас жил бүр хийдэг нийгмийн даатгалын сангийн 2025-2027 оны төсвийн төсөөлөл боловсруулахад шаардлагатай тэтгэврийн даатгалын сангийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа, 2025-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулахад оролцон холбогдох баримт судалгаа мэдээллийг сангийн нягтлан бодогч, болон ажлын хэсэгт гарган өгч хамтран ажилласан. | 2024-01-01<br>2024-12-31 | 100% |

**ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Системын хэмжээнд шинээр нэвтэрсэн программ хангамж, хууль, журам, дүрмийг судлах | Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна | Жилийн турш | Жилийн турш | Шинэ системтэй холбоотой албан ёсны сургалт, цахим уулзалтуудад оролцохоос гадна системын ажиллагаанд гарч байгаа гацалт, түүнээс үүдэлтэй алдааг залруулах зэрэг хүндрэлтэй асуудлуудыг цаг тухай бүрд нь судлан холбогдох мэргэжилтэн, албан хаагчидтай хамтран ажиллаж иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч ажиллаж байна. Шинээр томилогдон ажиллаж байгаа тэтгэврийн байцаагчдаа шинэ системд тэтгэвэр бодох, тогтоох, олгох үйлдлүүдийг зааж өдөр тутам дэмжиж урам өгч хамтран ажиллаж шинээр мөрдөгдөж буй "Нийгмийн даатгалын багц хууль", түүнийг дагалдан гарсан журам, дүрмийг хамт судлан хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй хийж гүйцэтгэн ажиллаж байна. | 2024-01-01 2024-12-31 | 100% |
| 2. | Албан хаагчид хэрэглэгчийн үнэлгээний веб програмыг ашиглан үйлчилгээгээ бүртгэх, иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн үнэлгээ авсан байх. | Үнэлүүлсэн байх | Жилийн турш | Жилийн турш | Иргэд даатгуулагчид, хамт олноосоо сэтгэл ханамжийн үнэлгээг байнга авч ажиллаж байна. | 2024-01-01 2024-12-31 | 80% |
| 3. | Байцаагчийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр шинэлэг ажил зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн байх | Жилийн турш | Жилийн турш | Цэвэр орчинг бүрэлдүүлж, өөрийн зүгээс агаарыг сайн цэвэршүүлж, хүчилтөрөгч ялгаруулдаг 3 сав цэцэг тарьж өрөө тасалгааныхаа өнгө үзэмж нэмсэн. | 2024-01-01 2024-12-31 | 85% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Тэтгэврийн байцаагч — Б. Цэцэгдэлгэр /..................../ — 2024 -12 -06

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*